



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.28 № 158

**Зөрчлийг арилгах тухай**

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ  
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ж.РАВДАНДОРЖ ТАНАА

“ЦДҮС” ТӨХК-ий 2012-2013 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийхэд доорхи зөрчил илэрлээ Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д “МУ-ын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа ААН, байгууллага нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргана.” 19.1.2-т “батлагдсан маягт, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг гаргах, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэж заасныг зөрчиж цахилгаан эрчим хүч үйлдвэрлэгч, хэрэглэгчидийн 33.9 тэрбум төгрөгийн авлага, өглөгийн тооцооны үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй,
- Нэмэгдсэн өртөгийн албан татварын тайланд цахилгаан эрчим хүчний борлуулалт, худалдан авалтын тооцоо 432,4 сая төгрөгийг тусгаагүй нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16.1-д “Албан татвар төлөгч нь бараа ажил үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварыг ... батлагдсан маягтын дагуу харьяалах татварын албанд тушаана.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн “Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн тухай” 15 дугаар зүйлийн 1-ийн 12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх” гэж заасныг үндэслэн Цахилгаан эрчим хүчний борлуулалтын авлага өглөг, тэг үлдэгдэлтэй нэгдсэн дансны ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусган, борлуулалт, худалдан авалтанд ногдуулсан татварыг НӨАТ-ын тухай хуулийн дагуу тайлагнаж зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2014 оны 3 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт болон “Од бүртгэл аудит” ХХК-д ирүүлэхийг “ЦДҮС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Равдандорж, Ерөнхий нягтлан бодогч С.Норовжамц нарт хариуцуулав.

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ**

**Г.НЯМДОРЖ**

**“ОД БҮРТГЭЛ АУДИТ” ХХК-ИЙ ЗАХИРАЛ**



**У.ОЮУНАА**